



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 11/105

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа 3 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын засаг дарга /Р.Мөнхтогтох/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 115 дүгээр захирамжийн хавсралтын 3 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс /Ж.Өлзийжаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



023000526

Дундговь аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 04 ны өдрийн 4/ дугаар захирамжийн 1-р хавсралт

№	Өмчлөгчийн			Хамтран өмчлөгчийн		Өмнөх захирамжийн		Өмнөх газрын		Газрын		Үнэ /төгрөг/
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Нэр	Регистрийн дугаар	Огноо дугаар	Холбогдох хэсгийн дугаар	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Хэмжээ /м2/	Байршил	
1	Ванчинбазар	Батмөнх	ЗЮ55111371			2006 №115	3		775	227	Айраг 1-16	726400
2	Дорж	Буянжаргал	ЗЮ71091666					111101377	300	352	Оч 3-1	1126400
3	Цэвэгжав	Саранчимэг	ЗИ66102604						900	1118	Мандал 17-28	3577600